



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2025.07.30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 87.8%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
50	23	5	6	-	5	6	5	73.8

“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2025 онд 50 хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 50 арга хэмжээнээс 100%-ийн хэрэгжилттэй 23 арга хэмжээ, 90%-ийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, 70%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 5, хэрэгжээгүй 6, хугацаа болоогүй 5 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 73.8 хувьтай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	хугацаа	Биелэлт	%
1	1.5. Төмөр	Төмөр замын	I-II	Зорчигчийн вагон худалдан	0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх	хөдлөх бүрэлдэхүүнийг 1ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ.	улирал	авах - "ТТЗ" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.02.21-ний А/07 шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон тул ТУЗ-ийн шийдвэрийг хүлээж байна.	
2.	1.12. Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах	Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна.	II улирал	/Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./	0
3.	3.1. Компанийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг дунд засвараар засварлах сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, засварлах ажлыг гүйцэтгэх.	50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна.	II улирал	"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд вагоны сэлбэг, хэрэгслийн худалдан авалт хүлээгдэж байна. Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой	0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.	
4.	6.1. Төмөр замуудын БОННУ-нд тодотгол хийлгэж, батлуулах.	БОННУ-ний боловсруулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.	II-III улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
5.	6.2. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд модны тарьц суулгац тарих.	5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.	II улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
6.	6.3. Хөв байгуулах, зураг төсөв батлуулах.	Хөвийн зураг төсвийг батлуулсан байна.	I-II улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
7.	1.1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 1.0 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.75 сая.тн нийт 1.75 сая.тн	II улирал	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 0.19 сая.тн ачаа тээвэрлэж 34 хувийн биелэлттэй, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.22 сая.тн ачаа тээвэрлэж 26 хувийн биелэлттэй, нийт 0.41 сая.тн ачааг тээвэрлэж төлөвлөгөө 29.2 хувийн биелэлттэй байна. Тайлбар; /Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд,	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.	
8.	2.3. Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах.	Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна.	I улирал	"Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хэлэлцүүлэх тухай" албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 01/379 дүгээр албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08/1150 тоот албан бичгээр Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг дахин сайжруулах тухай хариуг ирүүлсний дагуу сайжруулалт хийж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолтой хамааралтай компанийн өөрчлөлтөөс шалтгаалан "Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	30
9.	2.5. "Богдхан төмөр зам" төслийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад төслийн	Холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж гүйцэтгэл 100%-д хүрсэн	I-II улирал	Зам, тээврийн яамны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08/904 дугаартай "Нэрс ирүүлэх тухай" албан бичгийг ирүүлсэн. Албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3 дугаар тэмдэглэлд Богдхан төмөр замын төслийн явц цаашид авах арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах асуудлыг боловсруулж,	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	хүрээний баримт материалуудыг хүлээлгэн өгөх.	байна. Маргаан гарсан тохиолдолд холбогдох байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлсэн байна.		Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг даалгасан тул танилцуулга, материал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах нэрс ирүүлэх тухай дурдсан. Холбогдох ажилчдын нэрсийг хүргүүлсэн ба ажлын хэсгийн тушаал батлагдаагүй байна. Чиг үүрэг шилжсэн учраас МТЗ ТӨХК-иас тээврийн үйл ажиллагааны хоногийн мэдээг гаргаж байна.	
10.	8.10. Компанийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнчлэлээр элсэх ажлыг зохион байгуулж, элссэн байна	II улирал	Гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 4 чиглэлийн хүрээнд 20 ажил, арга хэмжээтэйгээр төслийг боловсруулж, Захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	30
11.	9.1. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.	Хууль, тогтоомжийн шийдвэрийг ханган ажиллаж, 2025 оны хийгдэх ажлыг 95 хувиас дээш дүгнүүлсэн байна.	I-IV улирал	Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийж үр дүнг тухай бүр удирдлагад танилцуулж байна.	30

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
7	6	-	1	-	100.0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай 2024.09.16 А/193

2.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, хил дамнасан төмөр замын зураг төслийг 2024 оны 10 дугаар сард багтаан магадлуулах, барилгын ажлын гэрээний төслийг Хятадын талтай эцэслэн тохирч 2024 оны 4 дүгээр улиралд багтаан баталгаажуулах, цаашид Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн өртөөдийн ачаа, вагон хуваарилалт, шилжүүлэн ачилт, галт тэрэг солилцоо болон ачаа тээврийн төлөвлөгөө зэргийг тохиролцох асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийх шаардлагын хүрээнд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн удирдлагын баг, бүрэлдэхүүнийг ур чадвар бүхий мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлж ажиллахыг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д.

Биелэлт: ЗТЯ-ны сайдын 2024 оны А/193 дугаар тушаалын дагуу Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн удирдлагын багийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, 01 дүгээр дүгнэлт гаргасан бөгөөд хувьцаа эзэмшигч компаниудын удирдамж, ТУЗ-ийн 11 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын 2, 3 дугаар заалтад Гүйцэтгэх захирлыг ажлын байрны тодорхойлолтод нийцүүлж байгаа эсэх, мөн удирдлагын багийн ажлын байрны тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг даалгасан. Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 2 дугаар дүгнэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын байрны тодорхойлолтод дүгнэлт гаргасан бол, компанийн удирдлагын багийн гишүүдэд Гүйцэтгэх захирал Н.Будбаяр дүгнэлт гаргаж, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 1/2886 дугаар албан бичгээр ТУЗ-ийн дарга Б.Артурт хүргүүлэн ажилласан. "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" хязгаарлагдмал компаниас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийн 1.4-т "Монголын талын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятадын хил доторх Хятадын талын тодорхойлсон Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгож болох бөгөөд Монголын талын барилгын ажил гүйцэтгэх гэрээг "Тавантолгой төмөр зам" ХХК болон гүйцэтгэгч нар харилцан тохиролцож гарын үсэг зурна" хэмээн өөрчлөлт оруулан, 4.9-д "Хилийн хамгаалалтын бүсийн хашаан доторх барилгын ажлын цар хүрээг төмөр замын шугамыг төв болгож, баруун, зүүн тийш 50 метрийн зайд тус тус тогтоох бөгөөд хоёр талын компани нь өөр өөрийн хилийн хамгаалалт, хилийн шалган нэвтрүүлэх, гааль зэрэг байгууллагуудыг хариуцаж барилга угсралтын ажилд үйлчилгээ үзүүлнэ" нэмэлтээр тус тус ирүүлсэн байна. Тус 4.9 дэх заалтын хүрээнд хэлэлцээрийн төсөлд санал авахаар 6/2497, 6/2498 дугаартай албан бичгээр Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн.

БНХАУ-ын "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХК-ийн зүгээс 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийн 1.4 болон 4.9 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн бөгөөд уг асуудлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллага буюу Гаалийн ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газраас тус тус санал авч, хэлэлцээрийн төсөлд оруулах Монголын талын саналыг боловсруулсан. Иймд



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

боловсруулсан хэлэлцээрийн төсөл, түүнд оруулах санал, танилцуулга болон холбогдох албан бичгийг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1/2655 дугаар албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн.

"Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" хязгаарлагдмал компаниас "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлтээр санал гаргасан ба тус саналтай холбоотойгоор 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр цахим уулзалт хийхээр төлөвлөж байна.

2/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх тухай 2025.01.07 А/01

Биелэлт: 2. Хил дамнасан төмөр замын барилгын ажил гүйцэтгэх хэлэлцээрийн төсөл боловсруулах, барилгын ажлын гэрээ байгуулахдаа олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, хамтран ажиллах, 2025 оны 04 дүгээр сард багтаан барилгын ажлыг эхлүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулах арга хэмжээ авч ажиллахыг Төмөр зам, далайн тээвэр бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), "Тавантолгой төмөр зам" ХХК (Н.Будбаяр)-д

Биелэлт: Хуулийн зөвлөх үйлчилгээ болон барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын явц

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолын 1.7 дахь заалтад тус тогтоолын 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллахыг даалгасан байдаг.

Түүнчлэн олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй хамтарч хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 08/1734, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 08/1830 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яамнаас ирүүлсэн байдаг.

Компанийн зүгээс Зам, тээврийн яамнаас ирүүлсэн "олон улсын дадлага, туршлагатай зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах" тухай чиглэлийг үндэслэн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг мөн онд зарласан боловч шаардлага хангасан этгээд тендер ирүүлээгүй шалтгаанаар сонгон шалгаруулалт амжилтгүй болсон.

3/ Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын тухай 2025.02.06 А/30

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтыг сайжруулах, дулааны цахилгаан станцын нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эзэмшлийн хагас вагонуудыг Дулааны цахилгаан станцуудын нүүрс тээвэрлэлтэд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл "Улаанбаатар төмөр зам" ХНН-т үнэ төлбөргүйгээр ашиглуулах арга хэмжээ авч ажиллахыг "Монголын төмөр зам" ТӨХК (О.Батчулуун), "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав), "Улаанбаатар төмөр зам" ХНН (Х.Хэрлэн)-т

Биелэлт: Зам, тээврийн сайдын А/30 тушаалын дагуу "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 200 хагас вагоныг буцаах ажлыг зохион байгуулж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 350 хагас вагоноос 100 вагоныг буцааж, үлдсэн 250 хагас вагоныг Шарын голын уурхайн нүүрс болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын экспортын эзсийн баяжмалын тээвэрт ашиглах саналыг Замын даргын 2025.04.08-ны өдрийн 03/1143 албан бичгээр Зам тээврийн яаманд хүргүүлсэн. Шийдвэр хүлээж байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	2	-	-	-	100.0

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
төсөв, гүйцэтгэл	14	4	-	-	-	10	100.0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	2	-	-	-	4	100.0
бусад	8	5	-	-	-	3	100.0
Нийт	28	11	-	-	-	17	100.0

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Нийт заалт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	Хамаа ралгүй	
46	25	2	2	5	3	1	8	78.1

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1. 1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр 0%

Биелэлт:

2. 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам

Биелэлт: - байхгүй 0%

3. 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам

Биелэлт: Стратеги төлөвлөгөө-2025 урт хугацааны стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн 2021-2023 онуудад компанийн хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлэх бодлого удирдамжийг тодорхойлоход чиглэсэн болно. 0%

4. 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж

Биелэлт: 2024 оны жилийн эцсийн тайлан батлагдах болоогүй байгаа тул 2023 оны жилийн тайлан мэдээг оруулсан болно батлагдах үед нь оруулах болно. 30%



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

5. 1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт 30%

Биелэлт: Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг тухай бүр сайтад нээлттэй мэдээлэн ажиллаж байна. 30%

6. 3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл зэргийг Төрийн худалдан авах цахим сайтад тухай бүр байршуулан ажилласан. 30%

7. 3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл

Биелэлт: Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулав. 30%

8. 5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг

Биелэлт: Удирдах зөвлөлийн мэдээллийг байршуулсан 30%

9. 1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг

Биелэлт: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг зэргийг нээлттэй байршуулсан. 50%

10. 1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл

Биелэлт: байхгүй /Хуульд заасан үйл ажиллагааны статистик мэдээлэл сар бүр мэдээлэх нь хангалтгүй/ 50%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

"ТТЗ" ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний хугацааг улирал тус бүрээр төлөвлөөгүй байна. /1.3-1.6, 1.8, 1.9, 2.5, 3.2-3.6, 4.1, 4.2, 5.1, 5.2, 6.3, 7.1-7.7, 8.1-8.4, 8.6, 8.8-8.11, 9.1, 9.2/

Тус компани нь тухайн жилд хэрэгжүүлэх 50 арга хэмжээнээс 35 арга хэмжээг улирал бүр хэрэгжүүлэхээр хугацааг нарийвчлан тусгалгүй төлөвлөжээ.

Хэрэгжилтийн байдал:

1) "ТТЗ" ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 87.8%-тай байна.

2) Засгийн газрын 2025 оны “Тавантолгой–Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалтад холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилт, мөн Зам, тээврийн сайд болон дээд шатны байгууллагуудаас ирүүлсэн чиглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зэрэг шалтгааны улмаас дараах ажлууд Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан боловч төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг зорчигчийн вагоноор нэмэгдүүлэх,
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний боловсруулалтыг гүйцэтгэх,
- 5000 ширхгээс доошгүй модны суулгац тариалах,
- Хөвийн зураг төсвийг батлуулах,
- Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах,
- 50 ширхэг хагас вагоныг дунд засвар хийж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,
- Тавантолгой–Гашуунсухайт чиглэлд 1.0 сая тонн, Тавантолгой–Цогтцэций чиглэлд 0.75 сая тонн, нийт 1.75 сая тонн ачаа тээвэрлэх,
- “Тавантолгой–Даланзадгад–Шивээхүрэн” чиглэлийн ТЭЗҮ боловсруулах,
- “Богдхан төмөр зам” төслийн хүрээнд холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай холбогдох баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж, гүйцэтгэлийг бүрэн хангах ажил.

3) Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт нь хилийн бүсийн зохицуулалттай холбоотой Хятадын талаас хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулах санал ирүүлсэн, мөн олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах тендер амжилтгүй болсон зэрэг шалтгааны улмаас удааширч, төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

4) Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын тухай сайдын тушаалын хэрэгжилт хангалтгүй байгаа нь вагоны эзэмшигч байгууллагуудын вагон буцаах ажиллагаа бүрэн дуусаагүй, мөн үлдэгдэл вагоныг өөр тээвэрт ашиглах тухай саналыг холбогдох төрийн байгууллагаас шийдвэрлээгүй байгаатай холбоотой.

5) “ТТЗ” ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 50 арга хэмжээний хэрэгжилт 73.8% байна. Үүнээс 75.5% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 24.4% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

6) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	12	69.0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Зорилт 2. Монгол улсын хөгжлийн бодлогод туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ.	5	58.0
Зорилт 3. Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.	6	83.3
Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.	2	100.0
Зорилт 5. Статистик судалгаа, мэдээ тайлангийн үнэн бодит, шуурхай, хүртээмжтэй байдлыг хангана.	2	100.0
Зорилт 6. Байгаль орчны багц хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангана.	3	0
Зорилт 7. Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.	7	86.0
Зорилт 8. Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.	11	89.0
Зорилт 9. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.	2	60.0

7) Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд анхаарч, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт болон Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж ажиллах;

3. Бүрэн хэрэгжсэн 4 тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Засгийн газрын 2025 оны "Тавантолгой–Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, компанийн чиг үүрэг болон орон тоог цомхон, чадварлаг байхаар оновчтой зохион байгуулах ажлыг шуурхай хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг бүрэн биелүүлэхэд анхаарах;

2. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр зорчигчийн вагон худалдан авах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

3. "МТЗ" ТӨХК-тай хамтран төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;




ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	50	45	73.8
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	7	6	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	12	12	75.0
4	ТНБД-ын тушаалын биелэлт	2	2	100.0
5	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	28	11	100.0
6	Ил тод байдлын үнэлгээ	46	37	78.1
Нийт		145	113	87.8

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:





ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4. Төмөр замуудын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний боловсруулалтыг гүйцэтгэх болон хөвийн зураг төсвийг батлуулах ажлыг хойшлуулах шийдвэрийг судалж, эергээр шийдвэрлэх талаар санал хүргүүлэх;
5. Компанийн гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх үйл явцыг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллах;
6. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах тендерийг дахин яаралтай зохион байгуулж, хэрэгжүүлэх;
7. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгавар болох Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хилийн бүсийн зохицуулалттай холбоотой Хятадын талаас хэлэлцээрийн төсөлд нэмэлтээр гаргасан саналыг шийдвэрлэх цахим уулзалт хурлыг зохион байгуулах;
8. Арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ДҮГЭРЖАВ

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ИТГЭЛТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2025.07.30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 87.8%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
50	23	5	6	-	5	6	5	73.8

“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2025 онд 50 хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 50 арга хэмжээнээс 100%-ийн хэрэгжилттэй 23 арга хэмжээ, 90%-ийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, 70%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 5, хэрэгжээгүй 6, хугацаа болоогүй 5 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 73.8 хувьтай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	хугацаа	Биелэлт	%
1	1.5. Төмөр	Төмөр замын	I-II	Зорчигчийн вагон худалдан	0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх	хөдлөх бүрэлдэхүүнийг 1ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ.	улирал	авах - "ТТЗ" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.02.21-ний А/07 шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон тул ТУЗ-ийн шийдвэрийг хүлээж байна.	
2.	1.12. Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах	Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна.	II улирал	/Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./	0
3.	3.1. Компанийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг дунд засвараар засварлах сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, засварлах ажлыг гүйцэтгэх.	50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна.	II улирал	"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд вагоны сэлбэг, хэрэгслийн худалдан авалт хүлээгдэж байна. Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой	0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.	
4.	6.1. Төмөр замуудын БОННУ-нд тодотгол хийлгэж, батлуулах.	БОННУ-ний боловсруулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.	II-III улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
5.	6.2. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд модны тарьц суулгац тарих.	5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.	II улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
6.	6.3. Хөв байгуулах, зураг төсөв батлуулах.	Хөвийн зураг төсвийг батлуулсан байна.	I-II улирал	Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.	0
7.	1.1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 1.0 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.75 сая.тн нийт 1.75 сая.тн	II улирал	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 0.19 сая.тн ачаа тээвэрлэж 34 хувийн биелэлттэй, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.22 сая.тн ачаа тээвэрлэж 26 хувийн биелэлттэй, нийт 0.41 сая.тн ачааг тээвэрлэж төлөвлөгөө 29.2 хувийн биелэлттэй байна. Тайлбар; /Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд,	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

				Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.	
8.	2.3. Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах.	Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна.	I улирал	"Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хэлэлцүүлэх тухай" албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 01/379 дүгээр албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08/1150 тоот албан бичгээр Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг дахин сайжруулах тухай хариуг ирүүлсний дагуу сайжруулалт хийж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолтой хамааралтай компанийн өөрчлөлтөөс шалтгаалан "Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	30
9.	2.5. "Богдхан төмөр зам" төслийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад төслийн	Холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж гүйцэтгэл 100%-д хүрсэн	I-II улирал	Зам, тээврийн яамны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08/904 дугаартай "Нэрс ирүүлэх тухай" албан бичгийг ирүүлсэн. Албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3 дугаар тэмдэглэлд Богдхан төмөр замын төслийн явц цаашид авах арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах асуудлыг боловсруулж,	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	хүрээний баримт материалуудыг хүлээлгэн өгөх.	байна. Маргаан гарсан тохиолдолд холбогдох байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлсэн байна.		Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг даалгасан тул танилцуулга, материал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах нэрс ирүүлэх тухай дурдсан. Холбогдох ажилчдын нэрсийг хүргүүлсэн ба ажлын хэсгийн тушаал батлагдаагүй байна. Чиг үүрэг шилжсэн учраас МТЗ ТӨХК-иас тээврийн үйл ажиллагааны хоногийн мэдээг гаргаж байна.	
10.	8.10. Компанийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнчлэлээр элсэх ажлыг зохион байгуулж, элссэн байна	II улирал	Гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 4 чиглэлийн хүрээнд 20 ажил, арга хэмжээтэйгээр төслийг боловсруулж, Захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	30
11.	9.1. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.	Хууль, тогтоомжийн шийдвэрийг ханган ажиллаж, 2025 оны хийгдэх ажлыг 95 хувиас дээш дүгнүүлсэн байна.	I-IV улирал	Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийж үр дүнг тухай бүр удирдлагад танилцуулж байна.	30

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
7	6	-	1	-	100.0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай 2024.09.16 А/193

2.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, хил дамнасан төмөр замын зураг төслийг 2024 оны 10 дугаар сард багтаан магадлуулах, барилгын ажлын гэрээний төслийг Хятадын талтай эцэслэн тохирч 2024 оны 4 дүгээр улиралд багтаан баталгаажуулах, цаашид Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн өртөөдийн ачаа, вагон хуваарилалт, шилжүүлэн ачилт, галт тэрэг солилцоо болон ачаа тээврийн төлөвлөгөө зэргийг тохиролцох асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийх шаардлагын хүрээнд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн удирдлагын баг, бүрэлдэхүүнийг ур чадвар бүхий мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлж ажиллахыг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д.

Биелэлт: ЗТЯ-ны сайдын 2024 оны А/193 дугаар тушаалын дагуу Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн удирдлагын багийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, 01 дүгээр дүгнэлт гаргасан бөгөөд хувьцаа эзэмшигч компаниудын удирдамж, ТУЗ-ийн 11 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын 2, 3 дугаар заалтад Гүйцэтгэх захирлыг ажлын байрны тодорхойлолтод нийцүүлж байгаа эсэх, мөн удирдлагын багийн ажлын байрны тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг даалгасан. Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 2 дугаар дүгнэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын байрны тодорхойлолтод дүгнэлт гаргасан бол, компанийн удирдлагын багийн гишүүдэд Гүйцэтгэх захирал Н.Будбаяр дүгнэлт гаргаж, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 1/2886 дугаар албан бичгээр ТУЗ-ийн дарга Б.Артурт хүргүүлэн ажилласан. "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" хязгаарлагдмал компаниас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийн 1.4-т "Монголын талын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятадын хил доторх Хятадын талын тодорхойлсон Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгож болох бөгөөд Монголын талын барилгын ажил гүйцэтгэх гэрээг "Тавантолгой төмөр зам" ХХК болон гүйцэтгэгч нар харилцан тохиролцож гарын үсэг зурна" хэмээн өөрчлөлт оруулан, 4.9-д "Хилийн хамгаалалтын бүсийн хашаан доторх барилгын ажлын цар хүрээг төмөр замын шугамыг төв болгож, баруун, зүүн тийш 50 метрийн зайд тус тус тогтоох бөгөөд хоёр талын компани нь өөр өөрийн хилийн хамгаалалт, хилийн шалган нэвтрүүлэх, гааль зэрэг байгууллагуудыг хариуцаж барилга угсралтын ажилд үйлчилгээ үзүүлнэ" нэмэлтээр тус тус ирүүлсэн байна. Тус 4.9 дэх заалтын хүрээнд хэлэлцээрийн төсөлд санал авахаар 6/2497, 6/2498 дугаартай албан бичгээр Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн.

БНХАУ-ын "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХК-ийн зүгээс 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийн 1.4 болон 4.9 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн бөгөөд уг асуудлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллага буюу Гаалийн ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газраас тус тус санал авч, хэлэлцээрийн төсөлд оруулах Монголын талын саналыг боловсруулсан. Иймд



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

боловсруулсан хэлэлцээрийн төсөл, түүнд оруулах санал, танилцуулга болон холбогдох албан бичгийг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1/2655 дугаар албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн.

"Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" хязгаарлагдмал компаниас "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлтээр санал гаргасан ба тус саналтай холбоотойгоор 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр цахим уулзалт хийхээр төлөвлөж байна.

2/ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх тухай 2025.01.07 А/01

Биелэлт: 2. Хил дамнасан төмөр замын барилгын ажил гүйцэтгэх хэлэлцээрийн төсөл боловсруулах, барилгын ажлын гэрээ байгуулахдаа олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, хамтран ажиллах, 2025 оны 04 дүгээр сард багтаан барилгын ажлыг эхлүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулах арга хэмжээ авч ажиллахыг Төмөр зам, далайн тээвэр бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт), "Тавантолгой төмөр зам" ХХК (Н.Будбаяр)-д

Биелэлт: Хуулийн зөвлөх үйлчилгээ болон барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын явц

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолын 1.7 дахь заалтад тус тогтоолын 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллахыг даалгасан байдаг.

Түүнчлэн олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй хамтарч хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 08/1734, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 08/1830 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яамнаас ирүүлсэн байдаг.

Компанийн зүгээс Зам, тээврийн яамнаас ирүүлсэн "олон улсын дадлага, туршлагатай зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах" тухай чиглэлийг үндэслэн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг мөн онд зарласан боловч шаардлага хангасан этгээд тендер ирүүлээгүй шалтгаанаар сонгон шалгаруулалт амжилтгүй болсон.

3/ Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын тухай 2025.02.06 А/30

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтыг сайжруулах, дулааны цахилгаан станцын нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эзэмшлийн хагас вагонуудыг Дулааны цахилгаан станцуудын нүүрс тээвэрлэлтэд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл "Улаанбаатар төмөр зам" ХНН-т үнэ төлбөргүйгээр ашиглуулах арга хэмжээ авч ажиллахыг "Монголын төмөр зам" ТӨХК (О.Батчулуун), "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав), "Улаанбаатар төмөр зам" ХНН (Х.Хэрлэн)-т

Биелэлт: Зам, тээврийн сайдын А/30 тушаалын дагуу "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 200 хагас вагоныг буцаах ажлыг зохион байгуулж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 350 хагас вагоноос 100 вагоныг буцааж, үлдсэн 250 хагас вагоныг Шарын голын уурхайн нүүрс болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын экспортын эзсийн баяжмалын тээвэрт ашиглах саналыг Замын даргын 2025.04.08-ны өдрийн 03/1143 албан бичгээр Зам тээврийн яаманд хүргүүлсэн. Шийдвэр хүлээж байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	2	-	-	-	100.0

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
төсөв, гүйцэтгэл	14	4	-	-	-	10	100.0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	2	-	-	-	4	100.0
бусад	8	5	-	-	-	3	100.0
Нийт	28	11	-	-	-	17	100.0

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Нийт заалт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	Хамаа ралгүй	
46	25	2	2	5	3	1	8	78.1

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1. 1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр 0%

Биелэлт:

2. 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам

Биелэлт: - байхгүй 0%

3. 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам

Биелэлт: Стратеги төлөвлөгөө-2025 урт хугацааны стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн 2021-2023 онуудад компанийн хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлэх бодлого удирдамжийг тодорхойлоход чиглэсэн болно. 0%

4. 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж

Биелэлт: 2024 оны жилийн эцсийн тайлан батлагдах болоогүй байгаа тул 2023 оны жилийн тайлан мэдээг оруулсан болно батлагдах үед нь оруулах болно. 30%



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

5. 1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт 30%

Биелэлт: Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг тухай бүр сайтад нээлттэй мэдээлэн ажиллаж байна. 30%

6. 3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

Биелэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл зэргийг Төрийн худалдан авах цахим сайтад тухай бүр байршуулан ажилласан. 30%

7. 3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл

Биелэлт: Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулав. 30%

8. 5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг

Биелэлт: Удирдах зөвлөлийн мэдээллийг байршуулсан 30%

9. 1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг

Биелэлт: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг зэргийг нээлттэй байршуулсан. 50%

10. 1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл

Биелэлт: байхгүй /Хуульд заасан үйл ажиллагааны статистик мэдээлэл сар бүр мэдээлэх нь хангалтгүй/ 50%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

"ТТЗ" ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний хугацааг улирал тус бүрээр төлөвлөөгүй байна. /1.3-1.6, 1.8, 1.9, 2.5, 3.2-3.6, 4.1, 4.2, 5.1, 5.2, 6.3, 7.1-7.7, 8.1-8.4, 8.6, 8.8-8.11, 9.1, 9.2/

Тус компани нь тухайн жилд хэрэгжүүлэх 50 арга хэмжээнээс 35 арга хэмжээг улирал бүр хэрэгжүүлэхээр хугацааг нарийвчлан тусгалгүй төлөвлөжээ.

Хэрэгжилтийн байдал:

1) "ТТЗ" ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 87.8%-тай байна.

2) Засгийн газрын 2025 оны “Тавантолгой–Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалтад холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилт, мөн Зам, тээврийн сайд болон дээд шатны байгууллагуудаас ирүүлсэн чиглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зэрэг шалтгааны улмаас дараах ажлууд Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан боловч төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг зорчигчийн вагоноор нэмэгдүүлэх,
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний боловсруулалтыг гүйцэтгэх,
- 5000 ширхгээс доошгүй модны суулгац тариалах,
- Хөвийн зураг төсвийг батлуулах,
- Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах,
- 50 ширхэг хагас вагоныг дунд засвар хийж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,
- Тавантолгой–Гашуунсухайт чиглэлд 1.0 сая тонн, Тавантолгой–Цогтцэций чиглэлд 0.75 сая тонн, нийт 1.75 сая тонн ачаа тээвэрлэх,
- “Тавантолгой–Даланзадгад–Шивээхүрэн” чиглэлийн ТЭЗҮ боловсруулах,
- “Богдхан төмөр зам” төслийн хүрээнд холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай холбогдох баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж, гүйцэтгэлийг бүрэн хангах ажил.

3) Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт нь хилийн бүсийн зохицуулалттай холбоотой Хятадын талаас хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулах санал ирүүлсэн, мөн олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах тендер амжилтгүй болсон зэрэг шалтгааны улмаас удааширч, төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

4) Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын тухай сайдын тушаалын хэрэгжилт хангалтгүй байгаа нь вагоны эзэмшигч байгууллагуудын вагон буцаах ажиллагаа бүрэн дуусаагүй, мөн үлдэгдэл вагоныг өөр тээвэрт ашиглах тухай саналыг холбогдох төрийн байгууллагаас шийдвэрлээгүй байгаатай холбоотой.

5) “ТТЗ” ХХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 50 арга хэмжээний хэрэгжилт 73.8% байна. Үүнээс 75.5% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 24.4% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

6) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	12	69.0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Зорилт 2. Монгол улсын хөгжлийн бодлогод туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ.	5	58.0
Зорилт 3. Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.	6	83.3
Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.	2	100.0
Зорилт 5. Статистик судалгаа, мэдээ тайлангийн үнэн бодит, шуурхай, хүртээмжтэй байдлыг хангана.	2	100.0
Зорилт 6. Байгаль орчны багц хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангана.	3	0
Зорилт 7. Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.	7	86.0
Зорилт 8. Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.	11	89.0
Зорилт 9. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.	2	60.0

7) Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд анхаарч, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт болон Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг тогтмол хэрэгжүүлж ажиллах;

3. Бүрэн хэрэгжсэн 4 тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Засгийн газрын 2025 оны "Тавантолгой–Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, компанийн чиг үүрэг болон орон тоог цомхон, чадварлаг байхаар оновчтой зохион байгуулах ажлыг шуурхай хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг бүрэн биелүүлэхэд анхаарах;

2. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр зорчигчийн вагон худалдан авах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

3. "МТЗ" ТӨХК-тай хамтран төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;




ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	50	45	73.8
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	7	6	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	12	12	75.0
4	ТНБД-ын тушаалын биелэлт	2	2	100.0
5	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	28	11	100.0
6	Ил тод байдлын үнэлгээ	46	37	78.1
Нийт		145	113	87.8

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:





ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

4. Төмөр замуудын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний боловсруулалтыг гүйцэтгэх болон хөвийн зураг төсвийг батлуулах ажлыг хойшлуулах шийдвэрийг судалж, эергээр шийдвэрлэх талаар санал хүргүүлэх;
5. Компанийн гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх үйл явцыг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллах;
6. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд олон улсын дадлага, туршлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах тендерийг дахин яаралтай зохион байгуулж, хэрэгжүүлэх;
7. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгавар болох Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хилийн бүсийн зохицуулалттай холбоотой Хятадын талаас хэлэлцээрийн төсөлд нэмэлтээр гаргасан саналыг шийдвэрлэх цахим уулзалт хурлыг зохион байгуулах;
8. Арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, товч, тодорхой, хоёр мянган тэмдэгтэд багтаан, тоо баримт, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ДҮГЭРЖАВ

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ИТГЭЛТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ